

СОНГОДОГ ТҮРЭГ ХЭЛНИЙ БИЧГИЙН СУДАЛГААНД ҮЗҮҮЛЭХ ӨНӨӨГИЙН
МОНГОЛ ХЭЛНИЙ АЧ ХОЛБОГДОЛ¹

Мехмет Левент Каяа

Хураангуй: Орхон бичээс хэмээн алдаршсан хөшөөг анх В.Томсен тайлбарласнаас хойш зуу гаруй жил өнгөрсөн бөгөөд бичээсийг бүрэн тайлан уншжээ. Харин бичээс дээрх түрэг хэлийг Европын аль нэг хэлээр голлон судалдаг байсан билээ. Энэхүү судалгаанд Орхон бичээсийг монгол хэлтэй харьцуулах нь илүү үр дүнтэй болох тухай өгүүлсэн болно. Мөн “Алтайн хэл”-ний онолд ч ихээхэн ач холбогдол үзүүлнэ гэж таамаглаж байна.

Өнөө хүртэл хэрэглэсэн судалгааны арга. Орхон бичээс хэмээн алдаршсан хөшөөг анх В.Томсен тайлбарлан уншсанаас хойш зуу гаруй жил өнгөрсөн бөгөөд бичээсийг бүрэн тайлж уншжээ. Тухайн хөшөөнүүдийн талаар өрнөдийн эрдэмтэд анх мэдээлсэн билээ. Тэдний олонх нь алтай судлаач биш, хятад судлаачид байсан учраас гол төлөв хятад сурвалжуудыг ашиглаж байв. Үүний дараа Европын судлаачид франц, герман, орос хэлээр судалгааны үр дүнгээ нийтлүүлэх болжээ.

Турк улсад уг бичээсийн тухай ном хэрэглэгдэхүүн, эсвэл хуулбарыг нь хэвлэсэн каталог ч байхгүй учраас судлаачдын олонх нь Европын улсууд, тухайлбал, Герман, Францын их сургууль, музейд очиж танилцан судалгаандаа ашигладаг байлаа. Туркийн судлаачдын дотор орос, хятад хэл мэддэг хүн тун цөөн учраас сүүлийн үе хүртэл тухайн улсуудад очиж судалгаа хийгээгүй байна.

Орхон бичгийн дурсгалын судалгааг нийтлүүлсэн герман, франц хэл нь Энэтхэг-Европ язгуурын хэл, харин турк хэл нь алтай хэмээх өөр язгуурын хэл гэж үзэж болно. Турк хэл нь Европ хэлнүүдээс үеийн тоо, эгшиг зохицох ёс, дагавар болон нөхцөлийн хэрэглээ, өгүүлбэр дэх үгсийн дараалал гэх мэт олон зүйлээрээ ялгардаг өөр хэл юм. Өөрөөр хэлбэл, түрэг хэлээр бичсэн өгүүлбэрийг Европын аль нэг хэл рүү орчуулахад бүтэц нь бүрэн өөрчлөгддөг байна. Дараа нь дахин үгийн дараалал ялгаатай түрэг эсвэл алтай язгуурын өөр нэг хэл рүү орчуулбал эх өгүүлбэртэй огт хамааралгүй шахуу шинэ өгүүлбэр бүтэхийг ч үгүйсгэх аргагүй.

Монгол хэлтэй харьцуулах нь. Одоо турк хэлний хоёр жишээ өгүүлбэрийг англиар орчуулаад дараа нь англи өгүүлбэрээ эргээд турк хэлээр буулгаж үзье.

Турк хэл: Bir haftadır boğazımdan sıcak bir şey geçmedi.

Англи хэлний орчуулга: It's been a week and still nothing I eat floats my boat.

Англи хэлнээс буулгасан нь: Bir hafta oldu ve boğazımdan sıcak bir şey geçmedi.

¹ Турк хэлээр нийтлэсэн өгүүллийн зохиогчийн орчуулсан монгол хувилбар. TÜRK KÜLTÜRÜNÜ ARAŞTIRMA ENSTİTÜSÜ YAYINLARI. YALIM KAYA BİTİĞİ OSMAN FİKRİ SERTKAYA ARMAĞANI. Найруулсан нь: Doç. Dr. Hatice ŞİRİN USER - Doç. Dr. Bülent GÜL. Ankara, 2013, pp.397-403.

Турк хэл: İnsanların Cengiz Han'ı bunca önemsesinin nedeni onu çok seviyor olmaları değil, ondan korkuyor olmaları. Yakın çağın insanların böyle bir sıkıntısı var işte: korkuya tapıyorlar.

Англи хэлний орчуулга: The reason why people were interested in Chinghiz Khan this much was not just because they liked him, but also because they were afraid of him. The problem with the modern age people was that they actually worshipped power.

Англи хэлнээс буулгасан нь: İnsanların Çingiz Kağan'a ilgi duymalarının nedeni onu sadece sevdiklerinden değil ayrıca ondan korktukları içindir. Modern çağın insanların sorunu, güce tapmalarıydı.

Энд нэг дэх болон гурав дахь өгүүлбэр ижил байх ёстой. Харин турк хэлнээс үгийн дараалал нэлээн ялгаатай англи хэл рүү, дараа нь дахиад турк хэл рүү орчуулахад хоёр өгүүлбэрийн бүтэц ч, хэрэглэсэн үгс ч өөрчлөгдсөн байгаа нь асар их ялгаа гарч буйг харуулж байна. Үүнтэй ижил жишээг “Монголын нууц товчоо”-оос татаж болно.

§74.

Ц.Дамдинсүрэнгийн текст =

Онон мөрнийг өгсөж уруудаж

Олирс мойлыг түүж явж

Өчүүхэн хөвүүдээ хайрлан тэжээж

Өдөр шөнийг аргацсан өнгөрүүлэв.

М.Л.Каяа-ийн текст =

Onon kıyısında inip çıkıp

Kuş üzümü böğürtlen toplayıp

Küçücük oğullarını sevgiyle besleyip

Gündüz geceyi bir biçimde geçirdi.

Э.Хэниш-ийн текст =

Lief sie am Onan-fluß aufwärts und abwärts,

Las Ebereschen und Moilcho-Beeren auf und

Fütterte Tag und Nacht die Kehlen der Kinder.

А.Тэмр-ийн текст =

Onan nehri boyunca bir aşağı, bir yukarı koştu,

Yabani armut ve moyilho (meyvası) toplayarak

Gece gündüz çocuklarını besledi.

§111.

Ц.Дамдинсүрэнгийн текст =

Хулд муу шувуу

Хулгана оготно идэх заяатай байтал

Хун галууг идье гэж

Хошуугаа билүүдэх мэт

М.Л.Каяа-ийн текст =

Kötü balıkçıl kuşunun

Yazgısı sıçan yemek iken

Kuşu kuşunu iyeyim diye

Gagasını bilemesi gibi

Э.Хэниш-ийн текст =

Ein gemeiner Vogel wie der Bussard

Hat nach seinem Lose Mäuse und Feldmäuse zur Nahrung.

Dabei aber begehrt er, Schwäne und Keiher zu fressen.

А.Тэмир-ийн текст =

Kötü huladu² kuşu için

Sıçan ve farelerle

Beslenmek mukadder olduğu halde,

Kuşu kuşlarına ve turnalara göz koyarak

Tamahkârlık eder.

Дээрх жишээнээс харахад, монгол хэлнээс герман хэл рүү орчуулахад зарим үг бүрэн дүйхгүй байгаагаас гадна мөрийн тоо ч өөр болсон байна.

Түүнчлэн аливаа хэлний хэлц хэллэг зэрэг нь маш өвөрмөц онцлогтой байх бөгөөд тухайн эх бичигт байгаа үг үндсэн утгаасаа гадна өөр утга илэрхийлэх ба шилжсэн утга нь үндсэн утгаасаа огт өөр нөхцөл байдалд хэрэглэгддэг. Энэ нь орчуулгын алдаа гарах шалтгааны нэг болно. Мэдээж, үүнд соёлын ойлголт нөлөөлнө. Хэтэрсэн нэгэн жишээ болбоос, машины моторын доторх кэм шафтад холбоотой системийг англи хэлтэй нийгэм өлгийдөж буй гар шиг харж байтал, италичууд энэ бүтцийг төгөлдөр хуур тоглох гартай зүйрлэж тайлбарлана.

Орчин цагийн түрэг хэлний хэл зүйн бүтэц болон илэрхийлэх аргуудад тухайн үеийн хэлтэй харьцуулахад нэлээн чухал өөрчлөлт буйг нэмбэл, шинжилсэн текстүүдийн бага ч гэсэн зарим нарийн зүйлсийг зөв ойлгож өнөөгийн хэлнүүдэд зөв дамжуулахдаа тааралдсан асуудлуудын үнэн учрыг илүү сайн ойлгож мэднэ.

Энэ асуудлыг тайлахад загвар болгох, тухайн үеийн хэлтэй төстэй, жишээг тайлж тайлбарлах зорилгоор ашиглаж болох өөр нэгэн хэв загвар хэл хэрэгтэй. Бид өөрсдийгөө азтайд тооцож болно. Учир нь ийм хэл манай үед бий. Тэр нь монгол хэл. Ялангуяа сонгодог түрэг хэлний үетэй холбоотой судалгаа шинжилгээний ажлын хүрээнд гардаг хамгийн том асуудал бол төрөл хэлнээс ирсэн зүйлс боловч энэ хоёр хэлийг зэрэг сурсан хэл шинжээч Турк улсад хэзээ ч байгаагүй.

Өнөөгийн монгол хэл бол үгийн бүтэц, дараалал, үгийн баялаг, зарим хэллэгийг илэрхийлэх арга зэргээрээ сонгодог үеийн монгол хэлтэй харьцуулахад бага өөрчлөгдсөн, тухайн үеийнхээ бүтцийг эдүгээ ч хадгалсаар байгаа хэл мөн. Түрэг болон монгол хэлний хооронд төстэй буюу дундын үгс, эсвэл үгийн баялгийн талаар одоо хүртэл хийсэн зарим судалгаа бий. Гэвч бидний мэдсэнээр уг хоёр хэлийг хэл шинжлэлийн талаас харьцуулсан судлаач гарын таван хуруунаас ч цөөхөн. Энэ тухай дурдахаас өмнө сэдэвтэй холбоотой бодит нэгэн жишээ татмаар байна.

Өөрийн нэр нь Леопольд Вэйсс байсан боловч ердөө Мухаммед Эсед гэж алдаршсан хүн Львов хотод Еврей гэр бүлийн хүү болон хорвоод мэндэлжээ. Тэр бээр Ибран хэл маш сайн мэддэг аж. Дараа нь исламын шашинд орохлоороо Куран сударыг илүү сайн ойлгоё хэмээн араб хэл сурахаар шийджээ. Эл зорилгоор Саудын Арабд суурьшсан байна. Олон зуун жил ижилхэн аж ахуй эрхэлж ирсэн цөлийн нүүдэлчин арабуудын хэл Куран судар буусан үеийн хэлтэй хамгийн төстэй байж болох юм гэсэн санаагаар долоон жил Бедуйн аймагт сууж, уламжлалт араб хэлийг төгс эзэмшжээ. Ингээд Куран судрыг англи хэл рүү орчуулсан байна. Уг орчуулгыг өнөөдөр ч исламын шашин судлаачид Куран судрын Европын олон хэлний орчуулгаас хамгийн зөв нь гэж үнэлдэг³.

² “huladu = хулд” туугун kuşu. Доор нь хэрээ гэж тайлбарлажээ.

³ http://en.wikipedia.org/wiki/Muhammad_Asad

Иймд би хоёр зүйлийг тодорхойлмоор байна. Нэгдүгээрт, түрэгийн сонгодог бичиг үүссэн эрин үетэй хамгийн төстэй аж ахуй эдүгээ хүртэл Монголд байсаар байна. Миний бие хэдийгээр хот сууринд нь амьдарч асан боловч тухайн үеийг илэрхийлэх, илүү тодорхой болгохуйц олон баримттай тааралдсан болно. Түүнчлэн хөдөө очвол тухайн үеийн аж ахуй, түүнийг илэрхийлэх үг хэллэгийг бүр дэлгэрэнгүй тайлбарлах завшаан олдоно.

Хоёрдугаарт, ерөнхийдөө гаднаас идэвхтэй оролдохгүй тохиолдолд уламжлал үргэлжлэх зарчим байдаг. Энэ ч илэрхийллээ өөрийн хэлэндээ олдог. Сонгодог түрэг ба монгол хэлний дундын үг олон ялангуяа бурхны шашин, улс төр, цэрэг, мал ахуйтай холбоотой үгээр баялаг гэдгийг өмнө нь олон эрдэмтэн дурдсан учраас энд давтах хэрэггүй биз. Нэмэлтээр, багштайгаа⁴ суралцаж байхдаа, монголчууд морио “гүррий-гүррий” гэж дууддагийг, тэмээгээ суулгахаар “сөх-сөх” гэж хэлдгийг сурч байв. Алдарт хэл шинжээч маань Кашгарын Махмудын Нэвтэрхий Толийг (Диван) уншихдаа ч, түрэгүүд морио “qurı-qurı” гэж дуудсан бөгөөд тэмээгээ ч “sök-sök” гэж судлах байсан гээд бичсэнийг үзээд бүр итгэлтэй болсон. Өөр нэгэн жишээ; монголчууд ялангуяа ахмад нь дуудвал “ө” гэж хандан хариулна. Дахиад Махмудын Нэвтэрхий Толинд “ö” гэсэн зүйлд “хэн нэгэн дуудвал ингэж хандан хариу өгдгийг” тэмдэглэжээ⁵. Ийнхүү авианы төсөөнөөс гадна, хоёр хэлэнд өгүүлбэр бүтээх талаар ч маш олон ижил төстэй зүйл байдаг. Жишээ нь:

temiz > цэвэр
 temiz+le- > цэвэр+лэ-
 temiz+lik > цэвэр+лэгээ
 temiz+lik+çi > цэвэр+лэг+ч
 gel- > ир-
 gel+eyim > ир+(ь)e
 gel+sene > ир+ээч
 gel+esin > ир+ээрэй
 gel+sin > ир+(э)г
 gel+e > ир+ээсэй
 tanı+n- > тань+гд-
 tanı- > тань-
 tanı+ş > тань+л
 tanı+t- > тань+ул-
 tanı+ş- > тань+лц-
 tanı+ş+tır- > тань+лц+уул-
 dil- > зүс-
 dilim > зүсэм
 dilim+le > зүсэм+лэ
 tarı- > тарь-
 tarı+g > тарь+a
 tarı+g+la > тарь+aa+лан

⁴ Проф. Д.Баасанбат. Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Сургууль, Хүмүүнлэгийн Ухааны Салбар, Монгол хэл, хэлшинжлэлийн тэнхимийн багш. Багшдаа судалгаанд минь оруулсан үнэлшгүй хувь нэмэр, хайр хүндлэл, тэвчээрт нь талархлаа илэрхийлмээр байна.

⁵ Кашгарын Махмуд, *Divan-ı Lüğati t-Türk*, “ö”, “qurı” ба “sök” зүйлс.

döv- > зод-

döv+üş > зод+оо

döv+üş- > зод+лд-

döv+üş et- > зод+оо хий-

Эдгээр нь хоёр хэлний үгийн бүтцийн хүрээнд маш олон ижил тал буйг заана.

Одоо энэ бичгийн гол сэдэв болохоор тухайн үеийн хэлний уламжлал монгол хэлэнд амьд буйг заах зорилгоор, тухайн үеийн түрэг бичээсээс хэдхэн өгүүлбэр жишээ болгон авч, тэдний өнөөгийн монгол хэлний тохирлын хэдэн жишээ үзүүлье⁶.

Көл Тигиний бичээсээс:

(У1)

teṅri teg teṅri-de bol-mış türük bilge kağan, bu öd-ke olur-tum.

тэнгэр шиг тэнгэр-т болсон түрэг билгэ хаан энэ үе-ээр суу-лаа.

(У1)

sab-ım-ın tüket-i eşid-gil!

үг-ийг минь төгс-төл сонс-чих!

(У8)

ötügen uıṣ olur-sar beṅgü il tut-a olur-taçı sen.

этүгэн тайга суу-вал мөнх улс барь-ж суу-на чи.

(У10)

türük begler, bodun, bun-ı eşid-iṅ!

түрэг ноёд, ард, үүн-ийг сонс-оцгоо!

(Д2)

tört buluṅ kor yaḡı er-miş.

дөрвөн булан бүгд дайсан бай-жээ.

(Д11)

törük bodun yok bolmazun tiyin, bodun bolçun tiyin, kaṅım ilteriṣ

kağan-ıḡ öḡüm

ilbilge katun-uḡ teṅri törü-sin-te tutup yügerü kötür-miş erinç.

түрэг ард үгүй болохгүй гэж, ард болог гэж, эцэг илтэриш хаан-ыг эх

илбилгэ хатан-ыг тэнгэр оргил-оос нь бариад дээш өргө-жээ шүү.

(Д38)

anta yana kir-ip türgiṣ kağan buyırıkı az totuk-uḡ eliḡ-in tut-dı.

тэнд дахин ор-оод түргиш хаан-ы дарга аз тотук-ыг гар-аар барь-лаа.

Билгээ Хааны бичээсээс:

(Д18)

üze teṅri basmasar, asra yir telinmeser, (D19) türük bodun, il-iṅ-in törü-g-

in kem artat-ı

u-daçı er-ti?

дээр тэнгэр эс дарвал, доор газар эс нүхэлбэл, (Д19) түрэг ард,

улс-ыг чинь төр-ийг чинь хэн эвд-эж чад-ах бай-лаа?

⁶ Бичээснүүдээс жишээ өгүүлбэрүүдийг Tekin T, *Orhon Yazıtları, Kül Tigin, Bilge Kağan, Tunyukuk, Yıldız, İstanbul, 2003*-оос авлаа. Монгол хэлний орчуулга нь М.Л.Каяа-ийнх болой.

(Д22)

...yir sayu bar-miş bodun...

...газар бүр оч-сон ард...

(Д31)

amgı korgan kış-la-duk-ta yut bol-tı.

амги корган өвөл-ж-сөн-д зуд бол-лоо.

Тонюкукын бичээсээс:

Нэгдүгээр хөшөө:

(Ө3)

türk bodun öl-ti, alkın-tı, yok bol-tı.

түрэг ард үх-лээ, мөх-лөө, үгүй бол-лоо.

(Ө6)

an-ta kisre tenri bilig ber-tük için, öz-üm ök kağan kış-dı-m.

түүн-ээс хойш, тэнгэр мэдлэг өг-сөн тул, өөр-өө л хаан хий-лээ би.

(Х4)

us-in sünüg-ün aç-dı-mız.

нойр-ыг жад-аар нээ-лээ бид.

Хоёрдугаар хөшөө:

(У2)

türük bodun temir kap-ıg-ka tinsi oğlu (G3) ayt-ıgma tag-ka teg-miş idi yok er-miş.

түрэг ард төмөр хаа-лган-д тинсигийн хүү (Г3) хэмээ-гээд уулан-д хүр-сэн огт үгүй бай-жээ.

(У5)

an-ta ay-guçı-sı yeme ben ök er-tim, yağı-çı-sı yeme ben ök er-tim.

түү-нд хэл-эгч нь ч би л бай-лаа, дайсан-ч нь ч би л бай-лаа.

(Д4)

işteriş kağan kazgan-ma-sar, udu ben öz-üm kazgan-ma-sar, il yeme bodun yeme yok er-teçi er-ti.

Илтэриш хаан эс ял-бал, ба би өөр-өө эс ял-бал, улс ч ард ч үгүй бай-х бай-лаа.

Дүгнэлт. Нэг язгуурын хоёр тусдаа хэл болох монгол, түрэг хэлний хооронд адил төстэй үгсээс гадна бүтцийн маш олон төсөөт хэв шинж байна. Уг бичээс дэх жишээнүүд нь өнөөгийн монгол хэл сонгодог түрэг хэлний хэв шинжийг агуулсан болохыг тодорхой харуулж байна. Энэхүү судалгаа нь тухайн чиглэлээр ажилладаг судлаачид монгол хэл сурах нь сонгодог үеийн түрэг хэлний бичээсүүдэд байх эртний үг хэллэг, нэр томъёо болон соёлыг ойлгоход чухал гэдгийг харуулаад зогсохгүй тухайн үеийн аж ахуйг ч илүү сайн мэдэхэд хувь нэмэр болно гэж үзэж байна.

Номзүй

- Дамдинсүрэн Ц, найр.** 1990. *Монголын нууц товчоо*. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар.
- Haenisch E.** 1941. *Die Geheime Geschichte der Mongolen*. Otto Harrasowitz. Leipzig.
- Kaşgarlı M.** 2007. *Divan-ı Lügati 'l-Türk*. Kabalcı. İstanbul.
- Kaya M L.** 2018. *Moğolların Gizli Tarihçesi*. Kronik. İstanbul.
- Temir A.** 1986. *Moğolların Gizli Tarihi*. TTK, Ankara. (1947).
- Tekin T.** 2003. *Orhon Yazıtları, Kül Tigin, Bilge Kağan, Tunyukuk*. Yıldız. İstanbul.